

2018 оны Үндсэн чиглэлийн төсөлд
мөнгө угаахтай тэмцэх асуудал тусгагдлаа

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гишүүн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог тодорхой хугацааны давтамжтай, тогтмол үнэлж, хянадаг. Тус байгууллагын Ази Номхон далайн бүсийн байгууллага болох (APG)-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг 8 Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх хоёр дах удаагийн “Харилцан үнэлгээ” 2016-2017 онд хийгдээд байна.

Ази Номхон далайн бүсийн байгууллагаас 2017 оны 7 дугаар сард Шри-Ланка Улсын Коломбо хотод хуралдсан жилийн чуулганаар Монгол Улсад хууль, эрх зүйн орчныг ФАТФ-ын 40 Зөвлөмжид нийцүүлэн богино хугацаанд өөрчлөх, 2018 оны 10 дугаар сард эргэн тайлагнах үүрэг даалгавар өгөгдөөд байна.

Жилийн чуулганы үеэр Монгол Улсыг “эрчимтэй хяналтанд” оруулсан нь Монгол Улсын эрсдэл нэмэгдэж буйн илрэл юм. Иймд, Монгол улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь дараах стратегийн зорилтуудыг хангах шаардлагатай болж байна. Үүнд:

1. Санхүүгийн гэмт хэргээс Монгол Улсын эдийн засгийг хамгаалах,
2. Эрчимтэй хяналтаас үүдэж болзошгүй сөрөг үр дагавараас зайлсхийх,
3. Корреспондент банкуудтай харилцах харилцааг алдахгүй тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах.

Монгол Улс эрчимтэй хяналтын “ажиглалтын үе” дуусахаас өмнө буюу 2018 оны 10 дугаар сараас өмнө мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомждоо нэмэлт, өөрчлөлт оруулж хэрэгжилтийг нь хангах үүрэг хүлээж байна.

Монгол Улс энэ үүргийг зохих түвшинд биелүүлэхгүй байх нь “саарал жагсаалт”-д орох үр дагавартай юм. “Саарал жагсаалт”-д орох нь санхүүгийн системд ноцтой эрсдэл учруулах, банкны гадаад гүйлгээ зогсох эрсдэлтэй билээ.

Ази Номхон далайн бүсийн байгууллагын шаардлагыг биелүүлэх ажлын хүрээнд 2017 оны 7 дугаар сард ҮАБЗ-өөс ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж гаргасан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 70 дугаар захирамжийн дагуу Монгол Улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Тус зөвлөл нь хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Засгийн газрын хэлэлцэж батлахаар сайшаасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 2018-2020 онуудад хэрэгжих дунд хугацааны

үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй билээ. Дунд хугацааны 8 9 Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл хөтөлбөр нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг болон эдгээрийг үйлдэж буй гэмт бүлэглэлүүдтэй тэмцэх олон улсын стандартад нийцсэн тогтолцоо бий болгох, хөгжүүлэх замаар санхүүгийн системийн тогтвортой, найдвартай байдлыг хадгалснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл нь Ази Номхон далайн бүсийн байгууллага (APG)-ын зөвлөмжийн дагуу дараах хууль тогтоомжийг нэн түрүүнд боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

- Зөрчлийн тухай хууль (мөнгө угаах гэмт хэргийн эсрэг авах хориг арга хэмжээ, Исламын улс/Аль-Каидагийн эсрэг авах хориг арга хэмжээний хүрээнд хөрөнгө битүүмжлэх үүргийг хэрэгжүүлэх г.м.) -2018 оны дунд үе;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль-2018 оны дунд үе;
- Исламын улс/Аль-Каида (НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1267-р тогтоол)-гийн эсрэг авах санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хуулийн төслийг боловсруулах - 2018 оны 9 дүгээр сар гэхэд хүчин төгөлдөр үйлчлэхээр;
- Зах зээлд ажиллахад тавих шаардлага, шалгуурыг зохицуулсан шинэ журмууд – 2018 оны 9 дүгээр сар

Хамтын ажиллагааны зөвлөл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Ази Номхон далайн бүсийн байгууллага (APG)-аас 2017 оны 7 дугаар сард гаргасан Харилцан үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, эрчимтэй хяналтанд орсонтой холбоотойгоор авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Монгол улс ажиглалтын үе буюу 2018 оны 10 дугаар сараас өмнө ФАТФ-ын 40 зөвлөмжид нийцүүлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль, эрх зүйн орчноо яаралтай өөрчилж, холбогдох олон тооны ажлыг хийж гүйцэтгэснээр “эрчимтэй хяналт”-аас гарах боломж бүрдэнэ.